

БАТЛАВ.



“ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХУДАЛДАН АВАХ” ГЭРЭЭ

Дугаар № ХНХЯ/202212019

07/2022
121 - 23 - 22-073

Улаанбаатар хот

Нэг талаас Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Ай Ти Зон” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 03 дугаар сарын 11-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Захиалагч нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын тоног төхөөрөмж худалдан авах тухай, ХНХЯ/202212019 дугаартай (цаашид “бараа” гэх) **49,596,910 /дөчин есөн сая таван зуун далан хоёр мянга таван зуун арван/** төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.

Энд: Тендерт шалгарсан үнэ 49,596,910 /дөчин есөн сая таван зуун ерэн зургаан мянга есөн зуун арван/ төгрөг (энд тендерт шалгарсан үнэ 41,560,310.0 /дөчин нэгэн сая таван зуун жаран мянга гурван зуун арван/ төгрөг нэмэлтээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.3-д заасны дагуу 8,036,600.0 /найман сая гучин зургаан мянга зургаан зуун/ төгрөг) байна.

2. Гэрээний үнийг нийлүүлэгч “Ай Ти Зон” ХХК-ийн харилцах Хас банкны **5000010323** дугаар дансанд шилжүүлнэ.

3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 2. Гэрээ баталгаажуулах маягт;
 3. Гэрээний тусгай нөхцөл;
 4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 5. Техникийн тодорхойлолт;
 6. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
- 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх/-ийн нэр: Шагдаржав
Нэр: Чинбат

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
- 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.8. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацаа;
 - 1.1.11. “Хоног” гэж хуанлийн хоногийг;
 - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;

- 1.1.14. "Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал" гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтын үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хэл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
- Тайлбар
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно;
 - 1.2.2. бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй;
 - 1.2.3. зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана;
 - 1.2.4. ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсэн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална;
 - 1.2.5. гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.
- ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ
- Бараа нийлүүлэх
- 2.1. Нийлүүлэгч нь Гэрээ болон Бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
 - 2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад тэдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна.
 - 2.3. ГЕН-ийн 1.4-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна.
 - 2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
 - 2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
- Бараа нийлүүлэх газар
- Барааг хүлээлгэн өгөх
- 2.6. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, тэмдэглэл үйлдэнэ.
 - 2.7. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.

- | | |
|------------------------------|---|
| Барааны гарал
үүслийн улс | <p>1.8. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.</p> <p>2.9. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.</p> |
| Баглаа боодол | <p>2.10. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.</p> <p>2.11. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд холбогдох хууль тогтоомжкоор хориглосон материал ашиглахыг хориглоно.</p> <p>2.12. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрднө.</p> |
| Худалдааны нөхцөл | <p>2.13. Гэрээнд хэрэглэж байгаа Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг ГТН-д заана.</p> <p>2.14. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр ГЕН-ийн 2.5-д заасан газарт хүргүүлэхнэ.</p> |
| ГУРАВ. ЗАХИАЛАГЧ | |
| Барааг хүлээн авах | <p>1.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.</p> |
| Шалгалт, туршилт | <p>3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.</p> <p>3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.</p> <p>3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.</p> <p>3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.</p> |
| Гэрээний үнэ | <p>3.7. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.8. Гэрээний үнэд тохицуулга хийхгүй.</p> |
| Төлбөр төлөх | <p>3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.</p> <p>3.10. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг</p> |

төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.

- 3.11. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.12. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.13. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс сутгана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

Захиалагчийн хүлээх эрсдэл

- 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна.

4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;

4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.

Даатгал

- 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.

Доголдол

- 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
- 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
- 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
- 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаа арилгана.
- 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
- 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.

Чанарын баталгаа

- 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас сутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
- 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
- 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.

- | | |
|--|---|
| | <p>4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаа гарган баталгаажуулж болно.</p> <p>4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаа гаргасан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнэ.</p> <p>4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.</p> <p>4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> |
| Алданги | <p>4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнэ.</p> <p>4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнэ.</p> |
| Оюуны өмчийн эрх зөрчих | <p>4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этээдийн оюуны өмчийн эрх зерчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> |
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал | <p>4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.8-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> |
| Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа | <p>4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>4.22. Захиалагч өрдийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг сунгаж болно.</p> <p>4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх өрдийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.8-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> |

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- | | |
|---|---|
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл | <p>5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:</p> <p>5.1.1. нийлүүлэгч үүргээ гэрээнд заасан хугацаанд, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч Нийлүүлэгч нэмэлт хугацаанд үүрэг гүйцэтгээгүй;</p> <p>5.1.2. бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;</p> <p>5.1.3. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авилгал, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.</p> <p>5.2. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.</p> <p>5.3. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.</p> <p>5.4. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл, гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.</p> |
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл | |

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- | | |
|-----------|--|
| Төлөөлөгч | <p>6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажлын болон өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.</p> <p>6.3. Гэрээг хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> |
| Нууцлал | <p>6.5. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтанд авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтд ил болгохгүй.</p> <p>6.6. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.</p> |

- | | |
|---|---|
| <p>Мэдэгдэл</p> <p>Маргаан
шийдвэрлэх</p> | <p>1.7. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>1.8. Гэнэтийн буюу давагдашгүй хүчиний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.7 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>1.9. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх, эсхүл шуудангаар нөгөө талын гэрээ Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>1.10. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <p>1.10.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</p> <p>1.10.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор тэмдэглэлийг үндэслэн;</p> <p>1.11. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>1.12. ГЕН-ийн 6.3-д заасан үүргээ биелүүлэхгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> <p>1.13. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p> <p>1.14. Талууд зөвшилцөн шийдвэрлэж эс чадвал Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гэрээний үүргийн гүйцэтгэл болон гэрээг цуцалсан, гэрээнээс татгалзсантай холбоотой аливаа маргааныг Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ.</p> |
|---|---|

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 2.1.	<p>Бараа нийлүүлэх хугацаа:</p> <p><i>Бараа нийлүүлэх хугацаа: 2022 оны 05-р сарын 01-ний өдрийн дотор]</i></p> <p>Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа: Бараа нийлүүлэлтийн хуваарь заасан хугацаанд багтааж хүргүүлнэ.</p>
ГЕН 2.5.	Бараа нийлүүлэх газар: Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, Бага тойруу 44а, Төрийн өмчийн XI байр, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,
ГЕН 2.6.	Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: Ажиллагаа, бүрэн бүтэй байдлыг холбогдох албан хаагчид шалгуулж хүлээлгэж өгнө.
ГЕН 2.10.	<p>Баглаа, боодол:</p> <p><i>Баглаа боодол нь тээвэрлэлтийн үеийн нөхцөл, тээвэрлэлт болон ил хадгалалтын үеийн халуун, хүйтэн, хур тунадас болон бусад бүх нөхцөлийг хангалттай тэсвэрлэхээр байна.</i></p> <p><i>Баглаа, боодлын хэмжээ, жинг сонгоходоо барааг хүргэх эцсийн цэгийн алслагдсан байдал, тээвэрлэлтийн цэг бүрд ачих, буулгах үйлчилгээг хариуцана.</i></p>
ГЕН 2.13.	<p>Худалдааны нөхцөл:</p> <p><i>Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлнэ.</i></p>
ГЕН 3.9.	<p>Төлбөр төлөх хугацаа:</p> <p><i>Төлбөр төлөх хугацаа: санхүүжилтийн эрх нээгдсэн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор</i></p>
ГЕН 4.2.	<p>Даатгал:</p> <p><i>[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалzan тодорхойлно. Даатгалын төрлийг тодорхой бичих]</i></p>
ГЕН 4.10.	Чанарын баталгаат хугацаа: 6-36 сар
ГЕН 4.11	<p>Чанарын баталгаа:</p> <p><i>Тоног төхөөрөмжийг актаар хүлээлцсэнээс хойш баталгаат засварын хугацаа дэлгэц, суурин компьютер 36 сар, А3 хэвлэх, хувилах, сканер 12 сар, принтер, рам, зөөврийн хард, график карт 6 сар байна</i></p>
ГЕН 4.17.	<p>Нийлүүлэгчийн төлөх алданги:</p> <p><i>Алдангийн хувь: [0]</i></p>
ГЕН 4.18.	<p>Захиалагчийн төлөх алданги:</p> <p><i>Алдангийн хувь: [0]</i></p>

Гэрээний хавсралт 1.


БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, БАРАА НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Баталгаат хугацаа	Нийлүүлэх хуваарь
1	Хувилагч	Canon Copier iR2425 A3, ХЭВЛЭХ / ХУВИЛАХ / СКАНЕР, 25PPM, 600X600DPI, 250 SHEETS CASSETTE, САРД 8300 ХУУДАС, WIRELESS LAN, DUPLEX	1	ш	12	Гэрээ байгуулсан ёдрөөс ажлын 5 хоногийн дотор
2	Принтер	HP Laser 107a	5	ш	6	Гэрээ байгуулсан ёдрөөс ажлын 5 хоногийн дотор
3	Дэлгэц	Dell Monitor E2420H 24-inch Screen LED Monitor	15	ш	36	Гэрээ байгуулсан ёдрөөс ажлын 5 хоногийн дотор
4	Суурин компьютер	Dell OptiPlex 3080 MT i3-10505, 4GB DDR4, M.2 256GB PCIE NVME CLASS 35, 8X DVD+-RW 9.5MM, K&M, NO OS	13	ш	36	Гэрээ байгуулсан ёдрөөс ажлын 5 хоногийн дотор
5	Суурин компьютер	Dell OptiPlex 7090MT i7 8GB 1X8GB DDR4 NON ECC MEMORY, M.2 256GB PCIE NVME CLASS 35 SSD, 8X DVD+,-RW 9.5MM OPTICAL DISK DRIVE, KEYBOARD, MOUSE, NO OS	4	ш	36	Гэрээ байгуулсан ёдрөөс ажлын 5 хоногийн дотор
6	RAM	Dell DRAM 8GB	5	ш	6	Гэрээ байгуулсан ёдрөөс ажлын 5 хоногийн дотор

7	Зөөврийн хард	Transcend TS1TESD370C USB 3.1 Gen-2 Type-C Portable SSD /TS1TESD370C/	1	ш	6	Гэрээ байгуулсан ёдреэс ажлын 5 хоногийн дотор
8	График кард	ASUS Phonix GeForce ^R GTX 1660 SUPER™	1	ш	6	Гэрээ байгуулсан ёдреэс ажлын 5 хоногийн дотор
9	График кард	ASUS Dual GeForce RTX2060 6GB GDDR6 Nvidia GeForce Graphics Card	1	ш	6	Гэрээ байгуулсан ёдреэс ажлын 5 хоногийн дотор
10	Компьютер ийн хард	Seagate 10TB 7200 RPM HDD	1	ш	6	Гэрээ байгуулсан ёдреэс ажлын 5 хоногийн дотор

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга



Ш.Чинбат

Хаяг: УБ, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу
44A, Төрийн өмчийн XI байр
Утас: 51-262737

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"Ай Ти Зон" ХХК-ийн Байгууллага
хариуцсан төлөөлөгч



Г. Гүнсүлд

Хаяг: УБ, Хан-Уул дүүрэг,
Стадион Оргил-1, Чингисийн
өргөн чөлөө-6, Хaan банк цамхаг,
22 давхар,
Утас: 323705, 89101090

ГЭРЭЭ ДҮГНЭХ МАЯГТ

2022 он 04 сар 18 өдөр

Гэрээний нэр:	"Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын тоног төхөөрөмж худалдан авах" гэрээ		
Гэрээний дугаар:	ХНХЯ/202212019		
Захиалагч байгуулага:	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар		
Гүйцэтгэгч байгуулага:	"Ай Ти Зон" ХХК		
Гэрээгээр ажил эхлүүлэх хугацаа:	2022 оны 03 дугаар сарын 11-ний өдөр		
Гэрээгээр ажил дуусгах хугацаа:	2022 оны 05 дугаар сарын 01-ний өдөр		
Гэрээний дүн:	49,596,910 төгрөг /Дөчин есэн сая таван зуун ерэн зургаан мянга есөн зуун арван төгрөг/		
Урьд санхүүжсан дүн:	0 төгрөг		
Нийт улдэгдэл:	49,596,910 төгрөг		
Батлагдсан гүйцэтгэлийн дүн: 49,596,910 төгрөг	Санхүүжилтийн дүн: 0 төгрөг		




Үүнээс БҮА	0	Үүнээс олгогдсон:	-
Техник хяналт:	-	-	-
Зураг төсөл:	-	-	-

Чанар баталгаат хугацаанд байршуулсан мөнгөн дүн /төгрөгөөр/	0 төгрөг
Гүйцэтгэгчээс ажил дууссан тухай мэдэгдэл ирүүлсэн өдөр:	2022 оны 04 сарын 11 өдөр Дугаар:22-JB04-031
Комиссын акт дугаар:	2022 оны 04 сарын 18 өдөр Дугаар:

Гэрээ биелэлт, шийдвэрлэлт

Гэрээний биелэлт:	Жишээ нь: Ажил бүрэн дууссан. Комисс комиссын акт 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн..... дугаартай баталгаажсан.
Шийдвэр:	Жишээ нь: Иймд алданги тооцохгүйгээр барьцаа хөрөнгө ... хувьтөгрөгийг Үлдээж улдэгдэл санхүүжилтийг олгохоор шийдвэрлэв.

ЖИЧ: Гэрээ хангалтгүй дүгнэгдсэн дохиолдол дэлгэрэнгүй хурлын тэмдэглэлийг доорх заалтын дагуу хөтөлж заавал хавсаргасан байх.

Гэрээ дүгнэсэн: 		Гүйцэтгэгч: 
"Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар" Мэдээлэл технологи, хяналт-шинжилгээ үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн: Ц.Чинзориг	“Ай Ти Зон” ХХК-ний дэд захирал: 	Б. Төрмөнх /
Тэмдэглэлтэй танилцсан: Захиалагч талаас: Хариуцсан мэргэжилтэн: Дарханбаяр / 		
Гүйцэтгэгч талаас, санхүү: Нягтлан Б.Одонгуя / 		